



## НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

### Эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Түр журам батлах тухай" А/48 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Дүрэм батлах тухай" А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Нийслэлийн Өргөө амаржих газрын дүрэм"-ийн 2.6.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт цагаан сарын баярын бүх нийтийн амралтын өдрүүдэд Өргөө амаржих газарт 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цаг хүртэл ажиллах эмнэлгийн тусламж үйлчилгээний зохицуулалтын түр журмыг нэгдүгээр, хариуцлагатай жижүүрийн хуваарийг хоёрдугаар, гүйцэтгэх үүргийг гуравдугаар, ажилтнуудын ажиллах хуваарийг дөрөвдүгээр, төрсөн эх, нярайг эмнэлгээс гаргах үйлчилгээг яаралтай түргэн тусламжийн төвтэй хамтран гүйцэтгэхтэй холбоотой "Эх нярайг гаргах түр заавар", холбогдох маягтуудыг тавдугаар, эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх эмгэг судлалын тасгийн эмч нарын ажиллах хуваарийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Удирдлагын баг зөвлөлийн бүрэлдэхүүн, тасгийн эрхлэгч, албадын дарга нар, хэсгийн ахлагч, арга зүйч эх баригч, арга зүйч сувилагч, бусад хариуцлагатнуудад энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг,
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ шаардагдах иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар, аюулгүй байдлын албаны дарга /С.Мөнхзул/, Эх барих тасгийн эрхлэгч /С.Алтантуяа/, Эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч /Д.Өнөржаргал/, Нярайн тасгийн эрхлэгч /Ж.Эрдэнэчимэг/, Оношзүйн тасгийн эрхлэгч /М.Хишигжаргал/ Сувилахуйн албаны дарга /Л.Амаржаргал/, Халдвар эсэргүүцэх дэглэмийн мөрдөлт, эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэн ажиллахыг Тархвар судлаач /Т.Энхбаатар/ нарт,
4. 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг

3149700311

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан АМ/36 маягтын дагуу Нийслэлийн эрүүл мэндийн газарт өглөө бүр 08 цагт burtgel.mohs.mn цахим программаар мэдээлхийг Мэдээлэл олон нийттэй харилцах албаны дарга, статистикч эмч /Д.Сумъяа/-д,

5. Хоолны хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн хоолны амт чанар, түгээлтэнд хяналт тавин ажиллахыг “Шинээ” ЗБН /З.Ариунаа/-д,

6. Гамшгаас урьдчилан сэргийлэх, сонор сэрэмж, ажлын цаг баримтлан хариуцлагаа дээшлүүлэн, хуваарийн дагуу ажиллахыг эмч, эмнэлгийн ажилтнуудад,

7. Баярын амралтын өдрүүдэд Өргөө амаржих газрын удирдлагын багийн гишүүд болон албадын дарга, тасгийн эрхлэгч, хэсгийн ахлагч, арга зүйч эх баригч, арга зүйч сувилагч, нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад холбогдох утсыг нээлттэй байлгахыг,

8. Тушаалыг хэрэгжүүлэн ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /О.Баянжаргал/, баярын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрт гарч ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг биеэр амруулахыг Хүний нөөцийн алба /Ж.Дэлгэрцэцэг/ нарт тус тус үүрэг болгосугай.

9. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Байгууллагын бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга /Г.Энхээ/-д даалгасугай.

ДАРГА



Г.БАЯСГАЛАН